



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дэх заалтыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Бат-Ирээдүй/-д даалгасугай.



ДАРГА

Б.МӨНХЦЭЦЭГ

1180100122

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийг үндэслэн дүүргийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах, дэг журмыг бэхжүүлэх ажлыг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тооцоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга удирдан зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

3. Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд тодорхой төрлийн гэмт хэргийн талаар судалгаа хийх эрдэмтэн, судлаачид, оюутнууд болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан судалгааны баг ажиллуулж болно.

4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан бөгөөд хуралдаанаар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын бодлого, чиглэл, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт, явц, үр дүн, жилийн ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт хийх, төлөвлөгөөг батлах, хэрэгжиж буй хөтөлбөрийн биелэлт, түүний үр дүнг хэлэлцэнэ.

5. Хуралдаанд зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувь нь оролцсноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

6. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэр нь тогтоол, зөвлөмж, албан даалгавар, тэмдэглэл, албан бичгийн хэлбэртэй байна. Шийдвэрт зөвлөлийн дарга гарын үсэг зурж тамга дарна. Хуралдааны тогтоол, зөвлөмж, албан даалгавар, тэмдэглэлийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх

талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд нь хариу мэдэгдэнэ.

7. Зөвлөл нь хэвлэмэл хуудас, тамга хэрэглэнэ.

8. Зөвлөлийн орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь зөвлөлийн даргын гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байж болно. Зөвлөлийн гишүүдийн оролцоог харгалзан урамшил олгоно.

9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг улирал, хагас бүтэн жилээр харъяалах дээд газарт хүргүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн үүрэг, эрх

2.1. Зөвлөл нь дор дурьдсан үүрэгтэй.

1. Төрийн буюу төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагуудын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг уялдуулан зохицуулах

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих

3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх бодлого, хөтөлбөр, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах талаар арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах талаар иргэд, байгууллагаас гаргасан санал санаачлагыг судлан дэмжиж, туслалцаа үзүүлэх, асуудал боловсруулан хамтран ажиллах

5. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг арилгах талаар арга хэмжээ авах

6. Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авах

7. Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлаж, чиглэл өгөх

8. Зөвлөлөөс зохион байгуулж буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах

2.2. Зөвлөл нь дор дурьдсан эрхтэй.

1. Дүүргийн хэмжээнд нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдралыг хангах зорилгоор зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг улирал тутам хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс гаргуулан авах

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах, сахилга зохион байгуулалтыг сайжруулахтай холбогдсон хууль журам, зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулах чиглэлээр нутгийн захиргаа, хууль хяналтын болон мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудад харъяалал харгалзахгүйгээр хяналт тавих, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж заалт, чиглэл өгөх

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийн явц, зарцуулсан хөрөнгийн тайланд дүгнэлт хийх, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих

4. Дүүргийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан, сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дүгнэлт гаргах, асуудал боловсруулах, шалгалтын ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллага, албан тушаалтныг татан оролцуулах

5. Шаардлагатай тохиолдолд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах

6. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд тодорхойлж уламжлах

7. Зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтанд хууль заасан арга хэмжээ авахуулах тухай удирдах байгууллага, албан тушаалтанд албан ёсоор мэдэгдэх

Зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажлын чиглэл

Нэг. Зохицуулах зөвлөлийн дарга

1.1. Зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг товлох, даргалах

1.2. Харьяа нутаг дэвсгэртээ нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах

1.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтийг тооцож ажиллах

1.4. Гарч буй гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр дүүргийн хэмжээнд шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх

1.5. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, холбогдох асуудлаар тогтоол, зөвлөмж, албан даалгавар гаргах

1.6. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

Хоёр. Зохицуулах зөвлөлийн орлогч дарга

2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах, удирдах ажилтны зөвлөгөөн, уулзалт, ярилцлагыг зохион байгуулах

2.2. Нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар дүрэм, журам, заавар боловсруулах, хэлэлцүүлэх

2.3. Хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

2.4. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

Гурав. Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, гарын авлага материал бэлтгэж тараах

3.3 Эргүүл, жижүүр, нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

3.4 Гэмт хэргийн мэдээг сар бүр нэгтгэн гаргах, зөвлөл болон салбар зөвлөлүүдэд хүргүүлэх

Дөрөв. Зөвлөлийн ажилтан

4.1 Зөвлөлийн ажилтан нь хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллана.

4.2 Хурлын тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрүүдийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, биелэлтийг нэгтгэх

4.3 Ирсэн бичигт хариу өгөх, тогтоол, шийдвэр, албан бичиг, төлөвлөгөөний төсөл боловсруулах

4.4 Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах

4.5 Зөвлөл, салбар зөвлөлүүдийн ажлыг бэхжүүлэх, эрчимжүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

Тав . Гишүүд

5.1 Хариуцсан ажлын чиглэлээр зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулан шийдвэр гаргуулах

5.2 Хуралдааны үед санал, шүүмжлэл, шийдвэр гаргахад идэвхтэй оролцох, хариуцсан байгууллага, хороондоо гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах талаар заавар, зөвлөгөө өгч, хамтран ажиллах

5.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах